



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/636

Мөрөн сум

Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн
бүтэц, орон тоо шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94.1 дэх хэсэг, Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5823:2016 стандартын 6.5.3 дах заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 22 дугаар хуралдааныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн бүтэц орон тоог хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэхүү захирамжийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж, байгууллагын 2025 оны цалингийн санд багтааж зохицуулалт хийхийг Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн дарга (Ч.Энхбат)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийг албажуулснаас хойш ажлын 3 өдөрт багтаан албан хаагчдад танилцуулж, шийдвэрийг мэдэгдсэн талаар баримт бүрдүүлж, бүтцийн өөрчлөлтөд орж байгаа албан хаагчдад хуулийн дагуу мэдэгдэл хүргүүлж ажиллахыг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн дарга (Ч.Энхбат)-д үүрэг болгосугай.

4.Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/63 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Гандэлгэр)-т даалгасугай.

ДАРГА



Г.ТӨМӨРБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр
сарын 27-ны өдрийн 16 дугаар
захирамжийн хавсралт



Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн бүтэц, орон тоо

№	Албан тушаалын нэр	Орон тоо
1	Төвийн дарга	1
2	Архив, бичиг хэргийн ажилтан	1
3	Нягтлан бодогч	1
4	Нярав	1
5	Их эмч	1
6	Сувилахуйн арга зүйч	1
7	Нийгмийн ажилтан	1
8	Сэтгэл зүйч	1
9	Ээлжийн тогооч	3
10	Үйлчилгээний ажилтан	4
11	Үйлчлэгч	1
12	Цахилгаанчин, сантехникч	1
13	Харуул хамгаалалтын ажилтан	4
14	Гэрээт ажилтан	4
	Нийт	25

_____оОо_____